

**Ж.Жуунайн “Бичмэл Жангар” ба “Зохиомол Жангар”-ын асуудалд<sup>1</sup>**

*Буудангийн МӨНХӨӨ\**

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Ганьсу муж, Лань жоу хот,  
Баруун хойдын үндэстний их сургууль  
Email: [13679430987@163.com](mailto:13679430987@163.com),  
<https://orcid.org/0009-0006-3594-5815>*

*Бүрэнбатын РЭГЗЭД\*\**

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Ганьсу муж, Лань жоу хот,  
Баруун хойдын үндэстний их сургууль  
Email: [2076313231@qq.com](mailto:2076313231@qq.com)*

**Received:** August 20, 2025 | **Accepted:** September 12, 2025 | **Published:** December 30, 2025

*Хураангуй: Ж.Жуунай бол БНХАУ-ын дотоод гадаадад алдаршсан жангарч төдийгүй “Жангар”-ын уламжлал шинэчлэл хийгээд судалгаа шинжилгээний хүрээнд нэлээд маргаан дагуулсан жангарч юм. Үүний нэг гол шалтгаан нь Ж.Жуунай эрдэм мэдлэгтэй сэхээтэн хүн байсан төдийгүй сонин сэтгүүлд шүлэг, мэдээ нийтлэл бичиж хэвлүүлдэг. “Жангар”-аа цээжээр хэлэхээс гадна хуулбарлан бичдэг туульч байжээ. Ялангуяа “Жангар”-ын хэд хэдэн шинэ бүлгийг “туурвин зохиосон”-оос болж, “Жангар”-ыг хэрхэн үнэлэх тал дээр “үнэн худал”-ын асуудал дурдагдаж, нэлээд маргаан гарчээ. Тус өгүүлэлд тусгайлан энэ асуудлыг хөндөж, зарим судлаачдын үзэж байгаа Ж.Жуунайн “Бичмэл Жангар” ба “Зохиомол Жангар”-ын тухай өөрийн санал бодлоо дэвшүүлсэн байна.*

*Түлхүүр үг: Ж.Жуунай “Жангар”, “Үнэн худал”-ын асуудал*

<sup>1</sup> Тус өгүүлэл БНХАУ-ын Сурган хүмүүжлийн яамны Гүн ухаан, нийгмийн шинжлэх ухааны төлөвжүүлгийн суурь мөнгөний тэтгэмжит том төсөл “Дундад улсын «Жангар»-ын эх хэрэглэгдэхүүний цуглуулга хийгээд судлал” (Зөвшөөрөгдсөн дугаар: 16JZDH032)-ийн хүрээнд бичигдэв.

\* © Б.Мөнхөө, 2025, Холбоо барих зохиогч

\*\* © Б.Рэгзэд, 2025

## Exploring Literary and Structural Issues in J.Juunai's Written Jangar and Fiction Jangar

MENGKAI,B

Northwest Normal University,  
Lan zhou city, Gansu, China

YIERJIDE, BURENBATE

Northwest Normal University,  
Lan zhou city, Gansu, China

**Abstract:** *J.Juunai is a renowned jangarch (traditional epic singer of Jangar), whose name is recognized both domestically and internationally, and who has sparked considerable controversy regarding innovation and scholarly interpretation of the Jangar tradition. One major source of this controversy is that J. Juunai was an intellectually trained figure with a strong background in literature who published poetry in newspapers and journals, and who not only performed his version of Jangar from memory but also committed it to writing. Notably, his creation of several new chapters of Jangar raised questions about authenticity, prompting debates on how his contributions should be evaluated, and stirring considerable discussion. The author of the article specifically addresses this issue and aims to present his own perspective on J.Juunai's Written Jangar and what some researchers refer to as the Fictional Jangar.*

**Keywords:** *J.Juunai's "Jangar", the issue of "Truth and Falsehood", literature, poetry, newspapers*

Алдарт жангарч, аварга туульч, цолгорсон үлгэрч, нэрт ерөөлч, ардын дуучин Жавын Жуунай (1926-2017) бол Шинжааны Ховогсайр Монгол өөртөө засах саяны Арван дөрвөн суман торгуудын Вангийн хошууны тэргүүн Их зүүн сумын нутагтаа ардын аман урлагчин юм. Түүний өвөг аав Эрхдэй болон эцэг Жав бол хоёр үеэрээ Ван ноёнд хүндлэгдэж ирсэн Вангийн ордны “Жангарч”, “Цэнгэлч” хүмүүс байжээ. Ж.Жуунай бол удам дамжсан жангарч бөгөөд тохмын жангарчийн гэр бүлд төрж өссөн. Түүний өвөг эцэг Эрхдэй, эмэг ээж Монцог, эцэг Жав нараас “Жангар” тууль болон ардын аман зохиолын сонгодог төрлийг байнга сонсож өссөн болохоор түүнийг хожим нь сайн жангарч, шилдэг ардын урлагчин, аман зохиолын баялаг урын сантай болгожээ. Ялангуяа түүнийг долоон настай байхад нь нагац Орлогожав чин ван болон Шаливаан гэгээний зарлигаар гурван хошууны тамгын их бичээч Бөөдэйн хөвгүүн Өлзийт гүздээд шавь орсноор 14 нас хүртлээ эрдэм ном сурч, судар ном сонирхон уншдаг байжээ. Өлзийт гүздээ олон үндэстний үсэг бичигт нэвтэрсэн, ном судар цуглуулан хадгалдаг авьяастай залуучуудыг сурган хүмүүжүүлэхийг чухалчлан үздэг холын бодолтой нэгэн байжээ.

Ж.Жуунай ингэж эрдэмтэн багш Өлзийт гүздээн хатуу шаардлага заавраар зүйр цэцэн үг, оньсого таавар, ерөөл магтаал, дуу хөгжим, үлгэр тууж, домог яриа, баатарлаг туульс зэрэг монгол аман зохиолын бүхий л төрөл зүйлээс сурч цээжилдэг байсан. Түүнээс гадна Өлзийт гүздээ бол эрдэм номтой хүн байсныхаа

хувьд Холвир Баяр, Шарын Насан зэрэг “жангарч” нараар өөрийн гэртээ “Жангар” туулийг хэлүүлж, жинхэнэ эхээс нь буулган бичдэг байжээ. Жуунай эдгээр жангарч нарын хэлсэн бүлгүүдийг сонсож цээжилдэг төдийгүй ялангуяа гар бичмэлийг нь уншиж цээжилдэг болсон байна.

Монгол соёл, тэр дундаа ойрад соёлын голомт болсон “Жангар”-ын нутаг Ховогсайрт төрж, өссөн Ж.Жуунай төрөлхийн авьяастай, цэцэн билигтэй нэгэн байжээ. Тэрээр удам дамжсан жангарчийн гэр бүлд хүмүүжиж, нэр төртэй жангарч болжээ. “Жангар”-ын туулийг хэлж өгөх ба бичиж уламжлуулах хоёр талаа хөгжүүлж, XXI зууны даяаршлын эрин цаг үед амьдарч байгаа бидэнд агуу их тууль “Жангар”-ыг амьд уламжлалаар нь өвлүүлж, нийт дөчөөд бүлэг “Жангар”-ыг үлдээжээ. Энэ бол Ж.Жуунай зөвхөн монголчуудын соёлд оруулсан том гавьяа төдийгүй хүн төрөлхтний эрдэнэсийн санд оруулсан чухал хувь нэмэр юм.

БНХАУ-ын аман зохиол, урлаг судлах нийгэмлэгийн Шинжааны Уйгар өөртөө засах орны нийгэмлэгээс эмхэтгэн хэвлүүлсэн “«Жангар»-ын эх материал”-ын VIII, IX дэвтэр бол Ж.Жуунай хэлж бичиж өгсөн “Жангар”-ын эмхэтгэл юм. Тус эмхэтгэлд нийт 25 бүлэг “Жангар” орсон ба тэдгээр бүлгийн дотор соронзон хальсны тодорхой дугаар бүхий 13 бүлэг оржээ. Бас соронзон хальсны дугаар тооны тодорхойлолт байхгүй боловч найруулагчаас “хэлсэн” хэмээх тодотголтой 2 бүлэг, хэлсэн ба бичсэн гэх тодотголтой 3 бүлэг, бичмэл 7 бүлэг байна. Д.Таяагийн “Жуунай гар бичмэл «Жангар»” номд нийт 17 бүлэг “Жангар” байж, тэдгээрийн дотор жинхэнэ бүлгийн шинжтэй зүйл 13, танилцуулга магтаалын шинжтэй зүйл 4 байна. Эдгээр бар хэвлэлээс гадна 1987 онд Шинжааны Ардын урлагчдын нийгэмлэгээс найруулж, Шинжааны Ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Жангар” (тод бичиг, гурван боть)-т нийт 13 бүлэг орсон ба түүний дотор “хэлсэн” гэдэг тодотголтой 10 бүлэг, “бичиж өгсөн” гэдэг тодотголтой 3 бүлэг байна. 2015 онд Шинжааны Ардын урлагчдын нийгэмлэгээс дэглэн найруулж, Шинжааны Ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Жангар” (Жангарчдын хайлсан уг текст тод бичиг, гурван боть)-ын хоёрдугаар ботид Ж.Жуунай хэлсэн 4 бүлэг “Жангар” оржээ. Дээрх хэвлэлд орсон бүлгүүдийн нийт тоо нь хувилбараа багтаагаад 59 бүлэгт хүрсэн явдал нь Ж.Жуунай нэр алдрыг алдаршуулж, хүмүүсийн хүндэтгэл бишрэл, магтаал сайшаалыг авахын зэрэгцээ бас “Жангар”-ын уламжлал залгамжлал хийгээд судалгаа шинжилгээний салбарт маргаан авчирсан жангарч юм. Үүний гол шалтгаан нь Ж.Жуунай бичиг ном мэддэг хүн байсан төдийгүй сонин сэтгүүлд мэдээ, шүлэг бичиж нийтлүүлдэг. “Жангар”-аа цээжээр хэлэхээс гадна хуулбарлан бичдэг байжээ. Ялангуяа “Жангар”-ын хэд хэдэн шинэ бүлгийг “Туурвин зохиосон”-соо болоод түүний “Жангар”-ыг үнэлэх тал дээр “Үнэн худал”-ын асуудал дурдагдаж, нэлээд шуугиан дэгдээжээ.

Ж.Жуунай хайлж, бичиж өгсөн “Жангар”-ын тухай анх мэдээлсэн хүн бол Ж.Батнасан юм. Тэрээр 1986 онд нийтэлсэн “«Жангар»-ын тууль ба Ховогсайрын жангарч нарын тухай байцаалтын мэдүүлэлт” гэдэг өгүүлэлдээ: “Жуунай бол икэл бийбаа татаж ‘Жангар’ хайлдаг бөгөөд өөрөө бичиж өгсөн ба хэлж шингээлгэсэн бүлгүүд нь нийт арван гурван бүлэг байгаагаас гадна, бас зургаан бүлэг хэлж чаддаг байсан тул нийт арван есөн бүлэг ‘Жангар’-ыг мэднэ гэж баталж болох юм. Жуунай хар багаасаа олон монгол судар, үлгэр туулиудыг уншиж хэлсэн хүн тул

“Жангар”-т заримдаа бусад ардын аман зохиолын зүйлс хутгалдан орсон нь харагддаг. Гэтэл үйл явдал нь хувираагүй уг эхээрээ бүрэн байж ихэнх бүлэг нь цэвэр чанараа хадгалсаар байна” (Батнасан, 1986: 636) хэмээн Ж.Жуунайн хэлж бичиж өгсөн “Жангар”-ын “цэвэр чанар”-ыг онцлон тэмдэглэжээ.

Гэвч үүнтэй харилцан адилгүй санал дэвшүүлэх үүднээс Ж.Жуунайн хэлж бичиж өгсөн “Жангар”-ын тухай нэлээд чухалчлан ажиглаж, 1990-ээд оноос эхлэн тусгай сурвалжилга, харьцуулсан судалгаа хийснийхээ үр дүнд Ж.Жуунайн хэлж, бичиж өгсөн “Жангар”-т үгүйсгэх хандлагатай судлаач бол Шинжааны их сургуулийн эрдэмтэн Жийжэйн Эрдэнэбаяр байсан. Тэрээр Жуунайн хэлж бичиж өгсөн “Жангар” бол уламжлалт Жангарын хөрс суурин дээр өөрийн авьяасаараа шинээр зохиосон зохиомол зүйл (Эрдэнэбаяр, 1991:3 хугацаа) мөн гэж мэдээлж байсан бол докторын зэрэг хамгаалсан “«Жангар»-ын тархац түүний газар зүйн хэв шинжүүд” гэх бүтээлдээ энэ асуудлыг нарийвчлан авч үзээд Ж.Жуунайн 25 бүлгийг сэдвийн үндэслэлээр нь “Халимаг ба Шинжаанд хэвлэгдсэн бүлгүүдийг дэлгэрэнгүй болгосон 13 хувилбар бүлэг, хуучин бүлгүүд дэх зарим үйл явдлын тухай товч мэдээлэлд тулгуурлан зохиосон 5 хиймэл бүлэг, “Хан харангуй” болон бусад туулийг өөрчилж “Жангар” болгосон 4 хуурамч бүлэг, үүсгэн зохиосон 2 шинэ бүлэг, уламжлалт бүлгүүдийг судалж тодорхойлсон сууринд зохиосон Жангар, Хонгорын намтар, гавьяа зүтгэлийн тухай 1 бүлэг хэмээн 5 ангилж болно” (Эрдэнэбаяр, 2010: 47) гэж дүгнэжээ.

1992 онд Шинжааны их сургуулийн багш Ц.Бат “Ж.Жуунайн ‘Жангар’-аас сэдэвлэн өгүүлэх нь” гэдэг өгүүлэл хэвлэжээ. Ж.Жуунайн намтар болон түүний хэлж бичиж өгсөн “Жангар”-т нарийн шинжилгээ хийсний үр дүнд “Хуучин бичгийн хүн, ахмад сэхээтний байр сууриндаа дулдуйдаж ‘Жангар’-ын бүлгүүдийнхээ олон бүлгийг бичиж өгсөн нь бусад жангарчдаас ялгарах онцлог болохыг энд тусгайлан тэмдэглэе” (Бат, 1992: 1 хугацаа) хэмээн дурдсан бөгөөд “Ж.Жуунайн бичиж, хэлсэн ‘Жангар’-ын бүлгүүдээс 13 бүлэгт ‘Жангар’-тай давхцах зургаан бүлэг, арван гурван бүлэгт ‘Жангар’-ын хувилбар болох хэдэн бүлгийг гаргавал үлдсэн бүлгүүдээс “Хан харангуй”, “Хан Шонутай” холбогдох бүлэг, ‘Хан харангуй’ туулийг өөрийнхөө ‘Жангар’-т шингээж дахин зохиосон ул мөр харагдаж байна. Ж.Жуунайн ‘Жангар’ бас арван гурван бүлэгт ‘Жангар’-ын сүүлийн гурван бүлгийн нөлөө ба монгол ардын аман зохиолын зарим тууль, домог, үлгэр зэрэг аман ба бичгийн зохиол, Энэтхэгээс гаралтай зарим үлгэр, туужийн үйл явдал, мотивыг ашиглан шингээх буюу ‘Жангар’-ын үйл явдлаас сэдэвлэж шинээр зохиосон тал ажиглагдаж байна. Шүлгийн холболтын талаар орчин үеийн шүлэг, бичгийн зохиолын шүлгийн онцлог байхын зэрэгцээ уламжлалт ‘Жангар’-ын зарим хэвшсэн шүлэглэлийг өөрчилсөн тал ч ажиглагддаг. Дайн байлдааны сэдэв, агуулга, мотив, дүрслэл харьцангуй багасаж сонин хачин ид шид, хишиг буяны тухай мотив олширчээ. Нэлээд бүлгийн зохиомж нь хятадын бүлэгт романы шинжтэй болж, үйл явдал нь бүрэн бүтэн шинжээ алдаж, зураглал, дүрслэл нь хэвшсэн зүйлгүй. Хэл хэллэгт нь уламжлалт ‘Жангар’-т байдаггүй өвөрмөц сонин хэллэг, туульсын бус орчин үеийн хэллэг цөөнгүй тохиолддог. Энэ нь Ж.Жуунайн “Жангар”-ын эдгээр өвөрмөц байдал нь түүний багш, өвөг аав, аав нь ном судар, “Жангар” цуглуулдаг бичигтэн төдийгүй ван ноёны жангарч байсан нь нөлөөлсөн. Жуунай багаасаа ном эрдэмд шамдаж, олон төрлийн ном судар уншиж, хошуу сумын бичээч болж явсан эртний бичгийн хүн. Ойрадын ахмад

сэхээтэн байсан нь Ж.Жуунайн ‘Жангар’ дахь шууд тусгал, бодитой илрэл мөн. Иймээс Ж.Жуунайн “Жангар”-т орчин үеийн бичгийн хүний ул мөр тодорхой байж, эртний нийгмийг итгүүлэх хүчээр сулхан, дуураймал ба зохиомол шинжтэй байдаг” (Бат, 1992: 1 хугацаа) гэжээ.

Доктор Б.Цогжин дээрхтэй адилхан санаагаар “Жангарчийн өөрөө хуулбарлан бичсэн ‘Жангар’-ын дэвтэрт бид анхаарал хандуулах хэрэгтэй. Бичиг үсэг, эрдэм ном эзэмшсэн чадвартай урлагчдын мэдлэг ухамсар, үг хэллэгийн боловсрол нь ном дэвтэрт нөлөөлөх учиртай. Мөн цаашдаа хэвлэлийн текстийн нөлөөллөөс болж - хэвлэлийн текстийн дотор байгаа зарим нэгэн сүвэгчийг улируулан хөгжүүлж шинэ бүлэг зохиох тохиолдол ч бий. Халимагийн ‘Жангар’-т: Хээ Жилганаас Алдар Жангарт хандан ‘Би хэзээний Шарайголын гурван хаантай заргалдаж заргаа авсан болдог’ гэсэн хэллэг байдаг. Магадгүй Ж.Жуунай энэхүү хэллэгийг үндэслэн хүн итгэхийн аргагүй урт бүлгийг зохиосон байж магадгүй. Ж.Жуунай бичиж өгсөн эх бичгүүдийн үнэн худлыг нь ялгахад хэцүү байдаг. Бас нэг хэсэг ‘Жангар’-аа өөрөө найруулан зохиосон гэж зарим хүмүүсийн хэлдэг нь оргүй үг биш” (朝戈金著, 2000: 67) гэжээ.

Дээр дурдсан Эрдэнэбаяр тэргүүтэй эрдэмтдийн өгүүлэлд зарим туйлширсан байдал ажиглагдах боловч бас зөв зүйтэй санал нэлээд байна. Үүнд:

Нэгд, Ж.Жуунайн хэлж бичиж өгсөн “Жангар”-т уламжлалт Жангарын суурь дээр өөрийн авьяасаараа шинээр зохиосон зохиомол бүлгүүд нэлээд байна.

Хоёрт, Халимагийн “Жангар”-ын бар хэвлэл, гар бичмэлийн тархалтын талаар Шинжааны монголчууд хүчтэй нөлөөлж байсан ба нэг хэсэг сэхээтэн хүмүүс халимаг “Жангар” дахь зарим үйл явдлын тухай товч мэдээллээс ямар нэгэн гэнэтийн сэрэл олох юм уу эсвэл зориудын ухамсартайгаар шинэ шинэ “Жангар”-ын бүлэг зохиодог байсан тухай Ж.Жуунай бол шинэ бүлэг зохиосон хүний төлөөлөгч мөн.

Гуравт, 1982 онд Ж.Батнасан, 1984 онд Т.Жамцын мэдээлсэн Ж.Жуунай мэддэг бүлгүүдийн жагсаалтад байхгүй байсан бүлгүүд сүүлийн үед нэмэгдэж, агуулга нь баяжиж Ж.Жуунай мэддэг бүлгүүдийн тоо олширсон тухай өгүүлдэг.

Дөрөвт, Ж.Жуунайн “Жангар” нь шүлэг холболтын талаар орчин үеийн шүлэг буюу бичгийн шүлгийн онцлог тодорхой байхын хамт уламжлалт ‘Жангар’-ын зарим хэвшсэн шүлэглэлийг өөрчилсөн байдаг.

Тавд, ном эрдэм сурч үсэг бичиг эзэмшсэн урлагчдын мэдлэг ухамсар болон үг хэллэгийн боловсрол нь ном дэвтэрт нөлөөлөх учиртай, цаашдаа хэвлэмэл текстийн нөлөөллөөс хэвлэлийн бичвэрийн дотор байгаа зарим нэгэн өгүүлэмжийг улируулан хөгжүүлж шинэ бүлэг зохиох тохиолдол ч байгаа тухай дэвшүүлсэн санаа нь бодит байдалтай нийцэж байна.

Гэвч жангарч гэсэн сайхан нэр ба эд мөнгөний ашиг тусыг олохын төлөө Ж.Жуунай энгийн уншигчдыг хууран мэхлэх арга хэрэглэж, “Жангар”-ыг хуурамчаар зохион хэлж, түүндээ гэрч болгож хуурамч баримт зохиож байсан овжин маягийн хүн болох нь нотлогдож байна. Энэ мэтээр хуурамч “Жангар” зохиож, худал баримт хэлж байгаа явдал нь эрдэмтдийг буруу замд оруулж “Жангар” судлалыг төөрөгдүүлж, аль болох зүй бус дүгнэлт гаргахад хүргэж байсныг хэлэх цаг болсон” (Эрдэнэбаяр, 2010: 53) ба Ж.Жуунайг ойрад уран зохиолын түүхэн дэх яруу найрагч хэмээн үзээд түүний хэлж, бичиж өгсөн “Жангар”-ыг уламжлалт “Жангар”-аас салгаж орчин үеийн ойрад уран зохиолын

түүхэнд оруулан судалбал зохино (Бат, 1992: 1 хугацаа) гэсэн сануулга гаргасан нь туулийн ба аман зохиолын онол ухагдахуун, дэлхий нийтийн сонгодог туульсын үүсэл төлөвшилтийн бодит байдалтай хараахан нийцэхгүй байгаагийн дээр тэдгээр үзэлтэй гүйцэд баримтаар нотлон баталгаажуулаагүй болохоор бид зөвшөөрөхөд хэцүү байна.

Дээр хэлсэнчлэн 1990-оны үед Ж.Жуунайн хэлж бичсэн “Жангар”-ын тухай судалгаанд бараг иймэрхүү үгүйсгэх, сэжиглэх, хардах өнгө аяс давамгайлж, эдгээр эрдэмтдийн үнэлэмж нь ардын итгэл үнэмшилд нөлөөлж “Жуунай бол жинхэнэ жангарч биш” гэх цуурхал нутгийн хүмүүсийн дунд тархсан байв. Үүний улмаас Хятад улсын “Жангар” бол хуурмаг “Жангар” гэдэг хэллэг олон улсын хэмжээнд тархаж байсан болохоор Дундад улсын Жангар судлалын нийгэмлэгийн дарга Хонгорын Бадай “Хятад улсын ‘Жангар’ бол дэлхий дээр хамгийн баялаг урлагийн үнэ цэнтэй эрхэм бүтээл болох юм. Хятад улсын ‘Жангар’-ыг худал, хуурмаг гэж худал гэх юм бол туйлын буруу болох юм”(Бадай, 1999: 2 хугацаа) гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Ж.Жуунай бол бичиг үсэгтэй жангарч болохоор түүний хэлж бичиж өгсөн “Жангар”-т адил бус хэмжээгээр бичгийн хэлний нөлөө туссан байдаг ба бичиг үсгээр тэмдэглэсэн ном судрын нөлөө нэлээд их байгаа нь бодит үнэн.

Бидний үзэхээр яруу найргийн төрмөл авьяастай Ж.Жуунай бага залуу насандаа эрдэм номд шамдаж, бийр янтайтай нөхөрлөж явахдаа шүлэг зохиохдоо мэргэжсэн ажээ. Энэ нь түүнийг шилдэг жангарч болоход нь ихээхэн тус болсон. Үнэндээ “Жангар”-ыг тэмдэглэн бичсэн явдал нь өв соёлдоо хайртай (өөрсдөө торгон дээл өмсдөггүй хэр нь ном судраа торгоор баринтагладаг) монгол угсаатны эртнээс уламжлалтай сайхан зан заншил билээ. Ижилийн Халимагаас аваад Шинжааны ойрад нутгаас “Жангар” тэргүүтэй олон ном судрын гар бичмэл удаа дараа олдож л байгаа нь үүний бодит баримт мөн. Харин ганц Ж.Жуунайн хувийн үүдэл хандлага огт биш юм.

Ж.Жуунайг бусад хүмүүсийн хэлснээс үзвэл, урьд цагт Өлзийт гүздээгийн бичүүлсэн гучин хоёр бүлэг “Жангар”-ын хөлгөн судраас ихэнх “Жангар”-ын бүлгийг сурсан<sup>2</sup> байжээ. Энэ нь Ж.Жуунайн “Жангар”-ыг улам үнэ цэнтэй, итгүүлэх хүчтэй болгохоос биш харин худал хуурмаг болгох ёсгүй. Бичиг үсэг мэдэхгүй хүний хэлсэн “Жангар”-ыг үнэн итгэлтэй жинхэнэ “Жангар” гэж үзээд харин бичиг үсэгтэй эрдэм номтой хүмүүсийн хэлсэн “Жангар”-ыг худал хуурмаг гэж үзэх нь ямар ч онолын үндэслэлгүй юм.

“Жангар”-ыг хамгийн анх бичиг үсэг мэддэггүй, эрдэм боловсролгүй эгэл жирийн ардын авьяастан буюу эсвэл хэд хэдэн ардын авьяастан хамтдаа сууж байгаад зөвлөлдөн зохиосон гэдэг баримт бидэнд байхгүй. Магадгүй “Жангар”-ын хамгийн анхны зохиогч нь Ж.Жуунай мэт бичгийн боловсролтой, аман соёлын баялаг нөөцтэй авьяастан байж болох бололцоо бас үгүй биш. Өөрөөр хэлбэл хэдэн зуун жилийн туршид “Жангар”-ыг уламжлуулахдаа олон тооны бичиг номтой жангарч, бичиг ном мэддэггүй жангарч нар бүр байлцсан гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй юм.

---

<sup>2</sup> Дундад улсын Ардын аман зохиол урлагийг судлах нийгэмлэгийн Шинжааны Уйгар Өөртөө Засах Орны салаа нийгэмлэгээс эмхэтгэн хэвлүүлсэн: “«Жангар»-ын эх материал” ⑨, Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо, 942-р тал.

Одоогоор Аримпилыг ном бичгийн боловсролгүй, жинхэнэ аман уламжлалыг баримтлан өчүүхэн ч хувиргахгүйгээр “Жангар”-ын уламжлалыг мөрдөн хайлдаг жангарч хэмээн үзээд түүний “Жангар”-ыг арай эрхэмлэх үзэгдэл газар авч байгаа тал байна. Бидний судалгааны үр дүнгээс үзвэл Аримпилын хайлан хэлсэн хэд хэдэн ижил бүлгийн хувилбарууд нь хоорондоо нэлээд зөрж байгаа бөгөөд эдгээр бүлгүүд нь “Уг хайллагад нь үнэнч байх зарчмаар ямар ч засалтгүйгээр буулгасан” эх хэрэглэгдэхүүн болох юм<sup>3</sup>. Харин зарим мэргэдийн хэлсэнчлэн “Өчүүхэн ч хувиргахгүйгээр” хайлж хэлсэн Аримпилын “Жангар”-ын бичвэрийг бид олж үзээгүй. Энэ нь сүүлийн үед судлаачдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн аман туулийн “үндсэн эх” гэж байдаггүй гэсэн томъёололтой нийцэж байгаа нь бодит байдал юм. Хэрвээ “Өчүүхэн ч хувиргахгүйгээр” хайлж хэлсэн эх текст үнэхээр байлаа гэж үзэхэд хүрвэл, Аримпилын “Жангар”-ын уг эх буюу “үндсэн эх” нь хэнийх вэ? харьцуулах боломж байна уу? хэнээс уламжлалтай вэ? хэдэн үе болж байгаа вэ? тэдний үе удам дотор, өвлүүлэн залгамжлуулсан олон үеийн жангарч багш нарын дотор бичиг номтой жангарч байсан бол энэ асуудлыг яаж үзвэл зүй зохистой вэ? гэдэг асуулт гарч ирж байна. Эртнээс Ховогсайр нутагт бичмэл хэлбэрээр тархаж байсан хэдэн арван бүлэг “Жангар” байсан гэдэг нь баттай юм. Эдгээр бичмэл “Жангар”-ын нөлөөлөл Аримпилд огт нөлөөлөөгүй гэж батламжлах бололцоо байна уу? бүх Шинжааны жангарчид дотор бичиг ном мэддэг жангарчид бол олон тоог эзэлнэ. Харин бичиг үсэг мэддэггүй жангарчид туйлын цөөн юм. Иймд тэдгээр бичиг соёлтой жангарчдын хайлсан “Жангар”-ын үнэ цэнийг буруушаах буюу цаашдаа “Хуурмаг Жангар” гэж хэлж болох уу? Ялангуяа Энэтхэг, Төвөд ба хятад хэлнээс орчуулсан уран зохиолын шинжтэй бичгийн зохиол, монголчуудын өөрийнх нь бичмэл судар номоос аман зохиолын хувилбарт хэлбэрээр тархаж дэлгэрсэн зохиол бол нэгэн том урсгал болох юм.

Бичиг үсэг мэдэхгүй хүний хэлсэн “Жангар”-ыг үнэн итгэмжтэй, жинхэнэ “Жангар” гэж үзээд харин бичиг үсэгт цагаарсан, ном эрдэмтэй хүмүүсийн хэлсэн “Жангар”-ыг худал хуурмаг “Жангар” гэж үзэхэд хүрвэл бүх аман зохиол, тэр дундаа туульсын зохиолыг үнэлж дүгнэхэд хүрвэл монгол аман зохиол, тэр ч байтугай хүн төрөлхтний аман зохиолын хэдэн мянга түмээр тоологдох үнэт бүтээлүүд бүгд “Худал хуурмаг” бүтээгдэхүүн болж гологдоно. “Орчин цагийн Хомер”, “Амьд Хомер”, “Манасын эцэг” зэрэг дэлхийд алдаршсан Манасч Жүсүф Мамайн хэлж бичиж өгсөн найман боть “Манас”-ын иж бүрэн тууль “Худал хуурмаг” малгай өмсөж Киргизүүдийн бахархал бус гутамшиг болж үлдэнэ. Бичгийн аман зохиол байснаасаа монгол аман зохиол болж хувьссан монгол ойрадын “Гэсэр”-ийн бүх хувилбарууд нь орчуулгаар дамжин монголчуудын дунд бичмэл ба аман уламжлалаар тархан дэлгэрсэн “Шидэт хүүрийн үлгэр” ба “Арж Борж хааны үлгэр”, “Ганжуур”, “Данжуур”-ын монгол орчуулгаар дамжин монголчуудын дунд ихэд тархсан “Үлгэрийн далай”, “Молон тойн”, “Маньбадарын тууж”, “Ушаандар” зэрэг үлгэр, тууж үнэ цэнээ алдаж “Худал

---

<sup>3</sup> Бид Д.Таяагаас дэглэн найруулж, Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 2013 онд хэвлүүлсэн “Аримпилын «Жангар» 23 бүлэг” болон Шинжааны ардын урлагчдын нийгэмлэг найруулж, Шинжааны ардын хэвлэлийн хорооноос 2015 онд хэвлүүлсэн “Жангар” (Жангарчдын хайлсан уг текст, тод бичиг, гурван боть)-ын доторх бүлгүүдийг харьцуулан шинжихэд ийм байлаа.

хуурмаг”-ийн хүлээсэнд автагдах болно.

Ж.Жуунай өөрөө “Жангар”-аа бичиж тэмдэглэсэн нь зарим эрдэмтдийн хэлдэг “Хуурмаг Жангар” зохиохын төлөө бус, үсэг бичигт түшиглэж зохиогоогүй харин өөрийн мэдэх аман уламжлалаа бичиг үсэгт буулгаж тэмдэглэн хойч үедээ мөнхийн өв болгон үлдээе гэсэн бодлого байв. Тэрээр ном бичиг мэддэг сэхээтэн хүний хувьд аль эрт 1956 оны 10 сараас эхлэн “«Жангар» ба аман зохиол тэмдэглэсэн ‘Чухал тэмдэглэл’ хэмээх улаан гадартай тэмдэглэлийн дэвтрээсээ 21 бүлэг “Жангар”-ын хувилбарыг бичиж өгсөн (Шинжааны “Жангар”-ын дугуйлангийнханд-эшлэгчээс)”<sup>4</sup> бөгөөд Д.Таяа зэрэг бусад хүмүүст өгсөн “Жангар”-ын гар бичмэл, жич нэг бүлгийг хэд хэдэн удаа засварлан хуулбарлаж бичиж байсан зэргийг харгалзуулан бодох юм бол олон гар бичмэл тархаж байжээ. Иймээс тэдгээр олон хүний гарт орсон гар бичмэл “Жангар”-ыг цуглуулах нь ч хожмын чухал ажил болж (Таяа, 2006: 377) байна.

Ингэж өөрийн мэддэг “Жангар”-аа хуулан бичих болсон тухайгаа Ж.Жуунай: “Би одоо угийн хэлж байсан шиг хэлж чадахгүй болов. Хэлэх бүлгийнхээ агуулгыг мэдэж байгаа ч нас өндөр болсноос хэлэх үед өмнө хойно нь хутгаж тархи толгой болохгүй байна. “Жангарын эхний бүлэг”-ийг хэлж байгаад юу хэлж байгаагаа мэдэхгүй болов. Заримдаа яг холбоогүй юмыг аваачаад хэлмээр байна. Ховогсайрын жангарчид ер нь “Жангар”-ыг ийм амтгүйгээр хэлдэггүй. Ингэж хэлснээс миний гараар бичсэн зүйлсийг аваад намайг зовоохгүй явчихвал болчихно” (Таяа, 2010: 281) гэж хэлсэн билээ. Үүнээс үзэхэд Ж.Жуунай гуай мэддэг чаддаг “Жангар”-аа аль чадахаар үнэн зөвөөр нь хойч үедээ уламжлуулахыг хичээж, хэдий чинээ цаг хугацаа зарцуулан байж хэдэн арван жил чармайж ирсэн гэдэг нь тодорхой байна. Үнэндээ аман соёл бол өөрөө хувирамтгай шинжтэй учраас түүнд “Эрх сүрт текст” буюу “Баримжаа текст” гэж байхгүй, түүнийг хуурмаг буюу жинхэнэ гэж ялгах нь утгагүй зүйл юм. Иймээс бид бичиг ном мэдэх эсэхээр “Жангар”-ын бүлгүүдэд “Үнэн худал”-ын үр дүн гаргах нь туйлын буруу ажиллагаа гэдгийг мэдрэх хэрэгтэй байна.

Эрдэмтдийн олон дахин давтаад байдаг Ж.Жуунай “Бичгийн хүний Жангар”, “Зохиомол Жангар”, “Шинэ Жангар”, “Хуурмаг Жангар”-ын тухай асуудлын талаар 1999 оны 12 сард Дундад улсын “Жангар” судлалын нийгэмлэгээс зохион байгуулж хуралдуулсан “Ж.Жуунайд алдарт жангарч цол олгох хийгээд эрдэм шинжилгээний ярилцах хурал” бол Ж.Жуунай хэлж бичсэн “Жангар”-ын судлалыг улам нэг алхам гүнзгийрүүлж, хүмүүсийн дундах янз бүрийн ойлголт үзэл бодлыг нэгдэлжүүлж чадсан хурал болсон юм.

Тус хурал дээр олон эрдэмтэн судлаач Ж.Жуунай хэлж, бичсэн “Жангар”-ын ач холбогдол, үнэ цэн, гавьяа зүтгэлийг сайшаан үнэлж, Ж.Жуунай бол нэрэндээ тохирсон алдарт жангарч мөн болохыг олон талаас нь баталсан байдаг. Ялангуяа профессор Дамбийпэлжидийн өгүүлэл нь Ж.Жуунай “Жангар”-т хэрхэн хандах тал дээр хүмүүсийн үзэл санаал зохих талаар өөрчилж чадсан юм. Профессор Дамбийпэлжид “«Жангар»-ын тууль ч гэсэн, эсхүл өөр ямар нэгэн тууль буюу үлгэр ч гэсэн, анх үүсэхдээ лавтай тусгай зохиогчтой байжээ. “Жангар”-аар авч

---

<sup>4</sup> БНХАУ-ын ардын аман зохиол урлагийг судлах нийгэмлэгийн шинжаан уйгар өөртөө засах орны салаа нийгэмлэгээс эмхэтгэн хэвлүүлсэн: “«Жангар»-ын эх материал” ⑨, Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо, 941-р тал.

хэлбэл, түүний зохиогч нь Төрбаяр өвгөн юм уу Түвшинжаргал эмгэн ч бай, эсхүл Эрлэг Номун хаанаас ертөнцөд дахин ирүүлсэн тэр нэгэн жангарч ч болог, тэдний зохиосон нь ‘Жангар’-ын эх бүлгүүд болж таарна. Энэ нь ‘Жангар’ туулийн тархан дэлгэрэх явцад өөр олон жангарч буюу туульч нарын оролцоотойгоор түүний агуулга нь нэмэгдэх буюу хэмжээ нь өргөсөх, дүр нь олширч зохиомж нь будилаантах, илтгэх арга барил нь шинэчлэгдэх уянгалах хэв намба нь өөрчлөгдөх зэрэг байдал бүр гарч болох юм. Энэ нь ардын аман зохиолын хөгжлийн жам ёс болж байна. Энэ нь сая ‘Жангар’-ын туулийн хамтач чанарыг харуулж байна. ‘Жангар’-ын тууль нь ардын аман зохиолын нэгэн хэсэг болохынхоо хувьд анх үүссэнээс аваад одоо үеийн жангарчдын амаар дамжиж ‘Эх бүлгүүд’-ээ уламжлахын дагууд өчнөөн төчнөөн шинэ бүлэг ба хувилбар болсон байдаг. Энэ нь ардын аман зохиолын хөгжлийн жам ёстойгоо нийцэж байгаа юм. Гэхдээ, тэдгээр шинэ хувилбар бүлгүүд нь ‘Жангар’ туулийн бүрдлийг төгөлдөржүүлж, агуулгыг баяжуулсан болохоос биш, өмнө зохиогдсон нь үнэн ‘Жангар’, хойно зохиогдсон нь худал ‘Жангар’ болох ёсгүй. Өдгөө бид Жуунай уянгалсан 28 бүлэг “Жангар”-ыг шинжлэхдээ иймэрхүү үндэслэл баримтлалтай байх ёстой. Жуунай “Жангар”-т бид хэдэн талын жишилт хийж болно.

Нэгд, Жуунай уянгалсан “Жангар”-ын 28 бүлэг нь тэр бүхнээр “Эх бүлгүүд” биш ч гэсэн бараг бүхэлдээ эрт дээр үеэс уламжилж ирсэн бүлгүүд болно. Үүнд хувилбар бүлэг багтана.

Хоёрт, жангарч Жуунайгаас түүний уянгалсан “Жангар”-ын бүлгүүдийнхээ зарим хэсэг буюу зарим үйл явдалд сэлбэлт хийсэн байж болно. Эрт урьдаас аваад “Жангар”-ыг амаар уламжилж цээжээр ярьдаг нь нэгэн жангарч нь “Жангар”-таа сэлбэлт хийх хэрэгтэй. Энэ бол жангарчдын эрх юм. Эртний жангарчдын энэхүү эрхийг зөвшөөрөөд өдгөөгийн жангарчдын энэхүү эрхийг хана гэвэл даанч ёс бус явдал болно.

Гуравт, Жуунай “Жангар”-таа зарим шинэ агуулга оруулах буюу цаашлан шинэ бүлэг нэмж зохиочихлоо гээд буруушаагдмаар явдал бус. Учир нь Жуунай бол авьяаслаг жангарч болохынхоо хувьд “Жангар”-т зарим талын сэлбэлт хийхээр үл барам, зарим талаар шинэ агуулга нэмж болох дархан эрхтэй гэдгийг үгүйсгэж болохгүй.

“Жангар”-ын үүслийг зарим хүмүүс VI-XII зууны үед гэдэг боловч зарим нь XV-XVII зууны үед авч хэлэлцэж байгааг бид даяар мэднэ. Энд бид XV-XVII зуунд гэдгийг баримталж асуувал: XVII зууны үеэр XV зууны үед зохиогдсон “Жангар”-т шинэ бүлэг зохиож, шинэ агуулга нэмж болдог. Гэтэл XX зуунд яагаад болдоггүй юм бэ? жангарч Жуунай “Жангар”-таа шинэ бүлэг нэмээд зохиочихсон юм бол, “Жангар”-ын тууль одоо ч “Амьд тууль” хэвээр байсаар байгаа гэдгийн ноттой гэрч биш үү? Хэрвээ ийм болдогт хүрвэл, энэ нь буруушаагдаад үл зохих явдал мөнөөр үл барам “Жангар” судлал дахь нэгэн шинэ сэдэв болох нь лавтай...Алдарт жангарч Жуунай уянгалсан “Жангар”-ын 28 бүлэг бол монгол соёлын үнэт өв мөн. Ялангуяа манай үед ганц нэгэн жангарчаас “Жангар”-ын олон бүлгийг сурвалжлан илрүүлсэн нь “Жангар” туулийн уламжлал ба судалгааны түүхэн дэх гайхамшигтай явдал мөн” (Дамбийпэлжид, 1999: 2-р хугацаа) гэж өндрөөр үнэлсэн юм.

Ж.Жуунай “Жангар”-ын үнэн худал нь “Шинэ зохиомол бүлэг”-үүдийг дүгнэж цэгнэх асуудлын талаар профессор Дамбийпэлжидийн дээр дурдсан үзэлтийг

үгүйсгэсэн өгүүлэл нэг ч гараагүй гараагүй нь тус байр суурь зөв зүйтэй болохыг баталгаажуулж байгаа юм.

Ж.Жуунайн “Жангар”-ын тухай судлаачдын адил бус саналыг эртнээс анхааран тус асуудалд өөрийн гэсэн байр сууриа илэрхийлсэн эрдэмтэн бол доктор Д.Таяа юм. Тэрээр “Ж.Эрдэнэбаярын ‘Дундад улсын Жангарын судалгааны нийгэмлэгийн анхдугаар ээлжит хурал’ хэмээх өгүүлэлд Жуунайн “Жангар” нь уламжлалт Жангарын суурь дээр өөрийн авьяасаар билгээрээ зохиосон зохиомол зүйл гэх саналыг анх дурдаад Жангарын жинхэнэ бүлгүүдийг шилэн сонгож Жангарын сонгодог эх дэвтрийг тогтоох тухай ярьсан байдаг. Цаашид Ц.Батын “Ж.Жуунайн Жангараас сэдэвлэн өгүүлэх нь”-д Ж.Жуунайн бичмэл ба аман Жангарын үг хэллэг, нэр томьёо нь бичгийн зохиолын нөлөөтэйгөөр барахгүй зарим бүлэг нь “Хан харангуй” зэрэг туулиас эх санаа авч зохиосон ул мөр харагдаж байгаа учраас “Ж.Жуунайн орчин үеийн ойрад уран зохиолын түүхэн дэх яруу найрагчаар үзэж, түүний хэлж бичиж өгсөн Жангарыг уламжлалт Жангараас салган одоо үеийн ойрадын уран зохиолын түүхэнд оруулбал зохино” гэж үзсэн байдаг. Үүний зэрэгцээ Дамбийпэлжидийн “Жуунайн хайлсан Жангарт болсон үндсэн танилт”, Б.Мөнхөөгийн “Алдарт жангарч Ж.Жуунай хийгээд түүний хэлсэн Жангарын өвөрмөц шинжийн тухай өгүүлэх нь” гэх зохиол нийтлэгдэж “Тэдгээр шинэ бүлэг ба хувилбар бүлгүүд нь Жангар туулийн бүрэлдлийг төгөлдөржүүлж, агуулгыг нь баяжуулсан. Харин өмнө зохиосон нь үнэн Жангар, хойно зохиосон нь худал Жангар болохгүй” гэдгийг дурдаж, өнгөрсний яриаг эс зөвшөөрсөн юм. Энэ асуудлыг шийдвэрлэхэд туулийг уламжлалт зохион бүтээх арга барилаар зохиох уу? Эсхүл бичгийн уран зохиолын нөлөөгөөр зохиох уу? гэдэг асуудлыг дурдах хэрэгтэй. Жангарч хэрвээ “Жангар”-ын уламжлалыг мөрдөн “Жангар”-ыг зохион бүтээх арга барилаар зохион бүтээж байх юм бол зохиомол буюу хуурмаг “Жангар” гэхэд учиртай юм. Хэрвээ үүний эсрэг байхад хүрвэл зохиомол “Жангар” хэмээн өгүүлэх бололцоотой. Гэхдээ туульсын уламжлалын хөрс суурь дээр бичгийн уран зохиолын нөлөөгөөр бичгийн уран зохиолын арга барилаар зохион бүтээж байх юм бол түүний уламжлал ба зохион бүтээлгийн харьцааг үзэх хэрэгтэй” (Таяа, 2010: 21) гэсэн чухал санал дэвшүүлсэн байдаг.

Доктор Д.Таяа энэхүү онолын үндэслэлдээ тулгуурлан Шинжааны жангарчдыг уламжлалыг дагаж хайлах уламжлалт жангарчид ба шинэчлэн хайлах шинэчлэлт жангарчид хэмээн хоёр хувааж, уламжлалыг баримтлагч жангарчдаас Жангар хайлах арга барилыг онгон дагшин байдлаар нь үзэж, багшийн хайлахыг өчүүхэн ч хувиргахгүйгээр хуучин уламжлалаар хайлдаг сайн талыг сайшаан магтсаны хамт уламжлалаар хайлахын хэвшлийг эвдэж Жангар хайлахад бүтээлчээр ханддаг “Шинэчлэлт” бүлэгдлийг ч магтан сайшаасан байна. Түүний үзэхээр үндэстнийхээ туулийн уламжлалын цар хүрээ хэмжээ, суурь дээр шинэчлэл хийх нь зүй ёсны хэрэг мөн (Таяа, 2010: 80) бөгөөд шинэ бүлэг зохиох бол жирийн ажил биш харин жангарчдын зохион бүтээх үйл ажиллагааны оргил хэсэг. Хэдэн зууны цогцлоосон жангарчдын олон удаагийн ухамсартай ухамсаргүй зохион бүтээх ажиллагаа нь “Жангар”-ын анхны дан туулийн хэлбэрийг хөгжүүлэн мөчлөг туулийн хэлбэрт шилжсэнээр өнөөдөр хүртэл орших боломжийг олгосон (Таяа, 2010: 185) хэмээх оновчтой санал дэвшүүлснийг бид мөн дэмжиж байгаа билээ.

Соёлын уламжлал залгамжлалын арга хэлбэр ихэвчлэн гурван зүйл байдаг. Үүнд:

Нэг нь аман яриа,  
Хоёр нь эд юмс ба бичиг тэмдэглэл,  
Гурав нь үйл ажиллагаа тэргүүтэн болно.

Амаар ярьж уламжлах бол соёлын уламжлалын анхны бөгөөд үндсэн нэг арга зам юм. Аман яриа бол хүн төрөлхтний хамгийн үндсэн уламжлалын арга зам мөн. Аман соёлын уламжлал бүхэн түүнд түшиглэсэн юм. Аман соёл бас бийр цаасанд тэмдэглэгдэн бичиг тэмдэглэлээр уламжилж залгамжлах учир буй, энэ нь аман соёлыг эд бодисын хэлбэрт оруулж, аман уламжлалыг алдагдах орхигдох аюулаас аварч, соёлын уламжлал залгамжлалыг улам найдвартай болгох учраас Ж.Жуунайн бичмэл “Жангар”-ыг бүрмөсөн үгүйсгэн “Худал хуурмаг Жангар” хэмээхийн оронд амьд туулийн онолын удирдамжаар жолоодлого болгож, шинжлэх ухааны үнэн бодитойд нийцсэн бүх талын нарийвчилсан судалгаа хийх нь зөв зүйтэй болов уу.

### Ном зүй

**Батнасан, Ж.** (1986). “Жангар”-ын тууль ба Ховогсайрын Жангарч нарын тухай байцаалтын мэдүүлэлт, Жангарын тухай өгүүлэх нь” ②, (Тод бичгийн хэвлэл), Шинжааны ардын хэвлэлийн хороо. [Batnasan, J. “Jangaryn tuuli ba Khovogsairyn Jangarch naryn tukhai baitsaaltyn medüülelt, “Jangariin tukhai ögüülekh ni. Shinjaany ardiin khevleliin khoroo. 1986.]

**Эрдэнэбаяр, Ж.** (1991). БНХАУ-ын Жангарын судлалын нийгэмлэгийн анхдугаар ээлжит хурал, *Өвөр Монголын үндэстний багшийн дээд сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл*. [Erdenebayar, J. BNKHAU-iin Jangariin sudlaliin niigemlegiin ankhdugaar eeljit khural, övör mongoliin undestnii bagshiin deed surguuliin Erdem shinjilgeenii setgүүл. 1991.]

**Эрдэнэбаяр, Ж.** (2010). *«Жангар»-ын тархац түүний газар зүйн хэв шинжүүд*, Улаанбаатар: [Erdenebayar, J. Jangariin tarkhats tüüni gazar züin khev shinjүүд. Ulaanbaatar]

**Бат, Ц.** (1992). “Ж.Жуунайн ‘Жангар’-аас сэдэвлэн өгүүлэх нь”, *“Өвөр Монголын үндэстний багшийн дээд сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл”*. [Bat, Ts. J. Zuunain Jangaraas sedevlen ögüülekh ni, övör mongoliin undestnii bagshiin deed surguuliin erdem shinjilgeenii ögüülel]

**朝戈金著**, (2000). “口传史诗学：冉皮勒<江格尔>程式句法研究”，广西人民出版社，2000年。

**Бадай, Хо.** (1999). “Дундад улсын ‘Жангар’ судлах хурлаас Ж.Жуунайд алдарт жангарч цол олгох хийгээд эрдэм шинжилгээний ярилцах хурлын нээлтэд хэлсэн үг”, “Хэл ба орчуулга” сэтгүүл. [Badai, Kho. Dundad ulsiin Jangar sudlakh khurlaas J. Zuunaid aldart Jangarch tsol olgokh khiigeed erdem shinjilgeenii yariltsakh khurliin neelted khelsen үг, Khel orchuulga setgүүл]

**Таяа, Д.** (2006). *Жуунайн гар бичмэл «Жангар»*, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо: [Taya, D. Zuunain gar bichmel “Jangar”, övör mongoliin ardiin khevleliin khoroo]

**Таяа, Д.** (2010). *Шинжааны жангарчийн уламжлал судлал*. Улаанбаатар: [Taya, D.

Shinjaanii Jangarchiin ulamjlal sudlal.]

**Тайван, О.** *Жангарч Жуунай болон Манасч Зүсүф Мамайн тухай үнэлэлтийн асуудалд*, (Алдарт жангарч Жуунай 90 насны ойд зориулсан ил нийтлэгдээгүй өгүүллээс).

**Дамбийпэлжид, П.** (1999). Жуунайн уянгалсан ‘Жангар’-т болсон үндсэн танилт, *Хэл ба орчуулга* сэтгүүл, 2-р хугацаа.



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>